САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# “БАНК БУС САНХҮҮГИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2022.10.20

Банк бус санхүүгийн байгууллагын газар

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## ББСБ-уудын тоо




## Харилцагчдын тоо




## Зээлдэгчдийн тоо




## Нийт актив







## Нийт зээл



# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

*Банкны салбартай харьцуулсан санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/*

| Үзүүлэлтүүд | 2021.II | 2022.II | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|
| Нийт хөрөнгө | 2,263.0 | 3,182.7 | 40.6% |
| *Банкны салбартай харьцуулахад хувиар* | 5.6% | 7.5% | 1.9% |
| Нийт өөрийн хөрөнгө | 1,553.4 | 1,981.6 | 27.6% |
| *Банкны салбартай харьцуулахад хувиар* | 49.0% | 48.8% | -0.2% |
| Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө | 1,047.9 | 1,230.0 | 17.4% |
| *Банкны салбартай харьцуулахад хувиар* | 127.7% | 76.8% | -50.9% |
| Нийт зээл | 1,571.9 | 2,497.8 | 58.9% |
| *Банкны салбартай харьцуулахад хувиар* | 8.0% | 10.5% | 2.5% |

*/Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт 2022.II/*

| Дүүрэг | Үндсэн | Салбар | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|
| | **438** | **256** | **694** | **100.0%** |
| Сүхбаатар дүүрэг | 147 | 35 | 182 | 26.5% |
| Чингэлтэй дүүрэг | 121 | 37 | 158 | 22.8% |
| Баянгол дүүрэг | 72 | 39 | 111 | 16.0% |
| Баянзүрх дүүрэг | 51 | 63 | 114 | 16.4% |
| Хан-Уул дүүрэг | 36 | 31 | 67 | 9.7% |
| Налайх дүүрэг | - | 3 | 3 | 0.4% |
| Сонгинохайрхан дүүрэг | 10 | 44 | 54 | 7.8% |
| Багануур дүүрэг | 1 | 4 | 5 | 0.7% |



*/ББСБ-уудын тархалт 2022.II/*

| Аймаг | Үндсэн | Салбар | Нийт | Хувь |
|---|---|---|---|---|
| | **89** | **149** | **238** | **100%** |
| Архангай аймаг | 2 | 5 | 7 | 2.9% |
| Баян-Өлгий аймаг | 4 | 4 | 8 | 3.4% |
| Баянхонгор аймаг | 4 | 6 | 10 | 4.2% |
| Булган аймаг | 1 | 1 | 2 | 0.8% |
| Говь-Алтай аймаг | 1 | 1 | 2 | 0.8% |
| Говьсүмбэр аймаг | 2 | 3 | 5 | 2.1% |
| Дархан-Уул аймаг | 7 | 13 | 20 | 8.4% |
| Дорноговь аймаг | 1 | 8 | 9 | 3.8% |
| Дорнод аймаг | 5 | 13 | 18 | 7.6% |
| Дундговь аймаг | - | 4 | 4 | 1.7% |
| Завхан аймаг | 2 | 3 | 5 | 2.1% |
| Орхон аймаг | 9 | 16 | 25 | 10.5% |
| Өвөрхангай аймаг | 10 | 11 | 21 | 8.8% |
| Өмнөговь аймаг | 2 | 14 | 16 | 6.7% |
| Сүхбаатар аймаг | 5 | 6 | 11 | 4.6% |
| Сэлэнгэ аймаг | 5 | 10 | 15 | 6.3% |
| Төв аймаг | 18 | 4 | 22 | 9.2% |
| Увс аймаг | 4 | 8 | 12 | 5.0% |
| Ховд аймаг | 1 | 4 | 5 | 2.1% |
| Хөвсгөл аймаг | 3 | 8 | 11 | 4.6% |
| Хэнтий аймаг | 3 | 7 | 10 | 4.2% |

# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ХАРИЛЦАГЧИД**
**4,404,136**

НИЙТ ХАРИЛЦАГЧИД ЭЗЛЭХ 92.8%

**ЗЭЭЛДЭГЧИД**
1,159,569

НИЙТ ЗЭЭЛДЭГЧИД ЭЗЛЭХ 76.3%

ЗЭЭЛИЙН ДҮН
319,804,840.7

НИЙТ ЗЭЭЛИЙН ДҮНД ЭЗЛЭХ 12.8%

1 зээлдэгчид олгох зээлийн ДУНДАЖ

275.8 мян.₮

**ФИНТЕК**
**36**



# ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

## Зээлийн багцын чанар




## Финтек зээлийн багцын чанар



# ЗЭЭЛИЙН ЖИГНЭСЭН ДУНДАЖ САРЫН ХҮҮ



# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Банк бус санхүүгийн байгууллагын газар

# ББСБ-ын салбарт мөрдөгдөж буй хууль

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

Банк, эрх бүхий хуулийн этгээд мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Валютын зохицуулалтын тухай хууль

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхт эй тэмцэх тухай

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай

# Хууль, эрх зүйн орчин



## Журам, заавар

- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай /2019.07.08 №210/
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай /2019.12.27 №441/
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах , шилжүүлэхэд мөрдөх журам батлах тухай /2020.01.15 №10/
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам /2020.12.09 №998/
- Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам /2021.04.08 №165/
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам /2022.04.06 №160/

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

## Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Энэхүү хууль батлагдсанаар ББСБ-ууд зээлийн үйл ажиллагаанд дараах шаардлагуудыг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Үүнд:

- Зээлдүүлэгч нь зээлийн зориулалт, хүүгийн хэмжээ, хугацаа болон бусад нөхцөлийг тогтоон нийтэд мэдээлэх
- Нэг төрлийн үйлчилгээнд үйлчилгээний шимтгэл, хураамжийг давхардуулан авахгүй байх
- Зээлдүүлэгч анх зээл олгохдоо зээлдэгчээр зээлийн хүүг урьдчилан төлүүлэхгүй байх

## Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Энэхүү хууль батлагдсанаар ББСБ-ууд зээлийн үйл ажиллагаанд дараах шаардлагуудыг хэрэгжүүлэхээр хуульчлагдсан. Үүнд:

- *Зээлийн хүүг зээлийг ашигласан хугацаагаар тооцох*
- *Зээлийн гэрээний үүрэг дуусгавар болсон тохиолдолд зээлдэгчийн зээлийн дансыг хааж, зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлж, энэ тухай эрхийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх*
- *Эрх бүхий хуулийн этгээд өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь, хэмжээг үндэслэлтэй тогтоох бөгөөд үүнд Монголбанк, СЗХ хяналт тавихаар хуульчлагдсан*

# Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам

**Журам нийт**
**6 бүлэг 34 зүйл 37 заалттай**.

Журмын ***зорилго*** нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, дэвшилтэт технологи ашиглан цахимаар зээлийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1. Нийтлэг үндэслэл
2. Зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим
3. Зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага
4. Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага
5. Финтек зээлийн үйл ажиллагааг бүртгэх, бүртгэхээс татгалзах, хасах
6. Хариуцлага

# Зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим



зээлийн **бүтээгдэхүүн, зориулалт, жилийн хүүгийн хэмжээ, хугацаа** болон бусад нөхцөлийг нийтэд ил тод мэдээлдэг байх;

**мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан** сэргийлж ажилладаг байх;

зээлдэгчид **зээлийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хүлээх эрх, үүргийг** танилцуулдаг байх;

харилцагчийн **мэдээллийн аюулгүй байдлыг** хангаж ажилладаг байх;

**мэргэжлийн ёс зүйтэй байх.**

# ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

***Зээлийн хүү бодох, барьцаа хөрөнгийг үнэлэхдээ*** эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, аргачлалыг мөрдлөг болгож ажиллана

Зээлдэгчийн зээлийн мэдээллийг өөрчлөлт орсон ***тухай бүр*** зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ

Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны ***ерөнхий нөхцөл*** болон дараах зүйлийг тусгасан баримт бичгийг баталж, мөрдөнө

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаат зээлийн барьцааны мэдэгдлийн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийг ***цахим мэдээллийн санд тухай бүр*** бүртгүүлж баталгаажуулна

***Зээлийн гэрээг зээлдэгчтэй бичгээр эсхүл техникийн хэрэгсэл***, програм хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан цахимаар байгуулж болно

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зээлдэгчийн ***санхүүгийн эх үүсвэр; гэрээгээр хүлээсэн зээл, төлбөр; зээл эргэн төлөх чадвар зэргийг харгалзан зээл олгоно***

Зээлийг гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хүүтэй болон хүүгүй олгож болно
Зээлийн гэрээгээр зээлийг хүүтэй олгох тохиолдолд зээлийн ***хүүг ашигласан хугацаагаар*** тооцно

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ***мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг*** хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан этгээдэд зээлийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзана

# ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэхдээ зээлдэгчид дараах шаардлагыг тавихгүй:

Option A

- зээл төлүүлэх зорилгоор зээлдэгчид аливаа хэлбэрээр хууль бус дарамт шахалт үзүүлэх;
- зээлдэгчээс зээл олгохтой холбоотойгоос бусад баримт бичиг, мэдээлэл шаардах;
- зээлдэгчээр зээлийн хүүг урьдчилан төлүүлэх;
  зээлийн хүүг шимтгэл, төлбөр хэлбэрээр тооцох;
- зээлдэгчээс гэрээнд тусгаагүй шимтгэл, хураамж төлөхийг шаардах;
- зээлдэгчийн барьцаа хөрөнгийг барьцаа хөрөнгөөс чөлөөлөхгүй байх;
- Хороонд бүртгэгдээгүй финтек зээлийн бүтээгдэхүүн гаргах;
- зээлдэгчид хуурамч ташаа мэдээлэл өгөх, төөрөгдүүлэх;
- зээлдэгчийн мэдээллийг хууль бусаар ашиглах, бусдад дамжуулах, хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах.

# Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

Финтек зээлийн бүтээгдэхүүний хувьд Хорооноос тогтоосон өр, орлогын харьцаа, эргэн төлөгдөх чадварыг харгалзана

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь финтек зээлийн бүтээгдэхүүний гэрээ байгуулж, шугам нээсэн тохиолдолд мэдээллийг тухай бүр Зээлийн мэдээллийн санд мэдээлнэ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд энэ журмын 4.4.-т заасан шаардлагыг хангасан гуравдагч этгээдээс аутсорсингийн үйлчилгээ авч болно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулах гэрээнд үйлчилгээтэй холбоотой гарах аливаа эрсдэлийг хэрхэн хариуцах талаар тодорхой тусгана.

**Финтек зээлийн бүтээгдэхүүн гаргахад мэдээллийн технологийн хувьд тавигдах шаардлагыг хангасан байна:**

**MNS ISO/IEC 27001:2021** стандартыг хангасан Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хийлгэж баталгаажуулсан байх;

кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэж баталгаажуулсан байх;

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# Анхаарал хандуулсанд баярлалаа